



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 4/23

Модот

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрх өвлөх тухай хүсэлт ирүүлсэн иргэн Хоролжавын Баяржаргал (ЕВ72080801)-ийн хүсэлтийг судлан үзээд, Оргодолмаагийн Ганболд (СУ69010878)-ын эзэмшлийн Цэнхэрмандал сумын 1-р баг, Хужхан, Нарангийн амны эх хаягт байрлах, 2321001706 нэгж талбарын дугаартай, өвөлжөө хаваржааны зориулалттай 10000 квадрат метр газрын эзэмших эрхийг иргэн Хоролжавын Баяржаргал (ЕВ72080801)-д шилжүүлсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар эзэмших эрх, үүргийг хэрэгжүүлж, төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэхийг газар эзэмшигчид даалгасугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэхийг сумын газрын даамлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан иргэн О.Ганболдын эзэмшлийн 000054951 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

С.ЗОЛЖАРГАЛ